



I-XII/2021

Тархаасан: 2022 оны 2 дугаар сарын 14



## Дотоод худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 оны 12 дугаар сард өмнөх сараас 38.8 хувиар өслөө

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 онд 27.8 их наяд төгрөг болж, өмнөх оноос 5.7 их наяд төгрөг буюу 26.0 хувиар өслөө. Үүнд хүнсний бүтээгдэхүүн, шатахууны бөөний болон жижиглэн худалдаа, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа, эм, гоо сайхан, ариун цэврийн барааны жижиглэн худалдаа тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 оны 12 дугаар сард 3.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 1.0 (38.8%) их наяд төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО<sup>1</sup>, жил бүрийн эцсийн байдлаар


	2019*		2020*		2021*		2021* I-XII
	XII	I-XII	XII	I-XII	XII	I-XII	2020* I-XII
	тэрбум төгрөг						хувь
<b>Нийт</b>	<b>2 848.7</b>	<b>23 646.9</b>	<b>2 737.4</b>	<b>22 028.4</b>	<b>3 659.2</b>	<b>27 760.4</b>	<b>126.0</b>
Бөөний худалдаа	1 183.2	8 728.3	1 130.2	8 281.6	1 466.8	10 684.9	129.0
Жижиглэн худалдаа	1 665.5	14 918.7	1 607.2	13 746.8	2 192.4	17 075.5	124.2

<sup>1</sup> Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо

Худалдааны салбарын 2021 оны борлуулалтын орлогын 38.5 хувь нь бөөний худалдаа, 61.5 хувь жижиглэн жижиглэн худалдааны салбарт ногдож байна.

Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2021 онд 17.1 их наяд төгрөг болж, өмнөх оноос 3.3 (24.2%) их наяд төгрөг, бөөний худалдааны борлуулалтын орлого 10.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 2.4 (29.0%) их наяд төгрөгөөр тус тус өслөө.

ЗУРАГ 1. ХУДАЛДААНЫ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, сараар, тэрбум төгрөг



Худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 оны 12 дугаар сард өмнөх сараас 1.0 их наяд төгрөгөөр өсөхөд төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа, хүнсний бөөний болон жижиглэн худалдаа, моторт тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийн жижиглэн худалдаа, шатахууны жижиглэн худалдаа тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 83.8 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 онд 23.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.8 (26.2%) их наяд төгрөгөөр өслөө. Худалдааны салбарын борлуулалтын орлого аймгуудад 7.7-55.2 хувиар өссөн байна.

ЗУРАГ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, аймгаар, жил бүрийн эцсийн байдлаар, тэрбум төгрөг



### Ойлголт, тодорхойлолт

Худалдааны нийт үйлдвэрлэлд бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчдадаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй)-г оруулна.

Худалдааны салбарын нийт борлуулалт нь тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалт бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.



### Эх үүсвэр:

ҮСХ, Дотоод худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын сарын мэдээ, НӨАТ төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

### Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

### Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

### Дараагийн мэдээ гаргах хуваарь: 2022 оны 3 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын дарга А.Дэмбэрэл  
 Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын статистикч Л.Энхбаатар  
 Утас: (976-51)-264797